АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# “ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ”

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС




Архангай аймгийн хөдөө аж ахуйн салбарын гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт 90 хувьтай, нийт хөрөнгийн 14.3 хувийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Аудитын дэлгэрэнгүй тайлантай танилцана уу.

2023 он

# ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Улсын хэмжээнд 2018-2022 онд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн 9 төсөл хөтөлбөрөөс 4 нь Архангай аймагт хэрэгжсэн байна

**НИЙТ ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ДҮН**
**4,709.0 САЯ ТӨГРӨГ**

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил 2000001604 /2019-2022 он/ буцалтгүй тусламж 2,634.0 сая төгрөг, Хөнгөлөлттэй зээл 1,282.9 сая төгрөг

118 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

**3,916.9 сая ₮**

**83.2%**

"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл /буцалтгүй тусламж/ 3287-MON, 3288-MON SF

**393.9 сая ₮**

**8.4%**

**8.2%**

**387.4 сая ₮**

"Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл" /зээл/ №112/00236091/210034

**0.2%**

**10.8 сая ₮**

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох /зээл/ МОН-3338

*Зээл* **1,681.1 сая ₮**

*Тусламж* **3,027.9 сая ₮**

| Он | Тусламж | Зээл |
|---|---|---|
| 2019 он | 598.0 сая ₮ | 387.4 сая ₮ |
| 2020 он | 1,139.7 сая ₮ | 1,282.9 сая ₮ |
| 2021 он | 982.7 сая ₮ | 10.8 сая ₮ |
| 2022 он | 307.5 сая ₮ | 0.0 сая ₮ |

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

**БҮЛЭГ 1.**

**Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байна**

**БҮЛЭГ 2.**

**Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийг бүрэн ашиглаагүй байна**

**БҮЛЭГ 3.**

**Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөө багатай байна**

**АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

**АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ 90 ХУВЬТАЙ, НИЙТ ХӨРӨНГИЙН 14.3 ХУВИЙГ БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА.**

## АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 390.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 212.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 177.5 сая төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмжийг Жаргалант, Өлзийт, Төвшрүүлэх, Хайрхан, Эрдэнэмандал сумын ЗДТГ-т болон гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийг ашиглагч нэр бүхий иргэн, ААН-д хүргүүллээ

## ЗӨВЛӨМЖ

**Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглагч "Нуурын овоо", "Баян уулын хишиг", "Малчин түмний буян" хоршооны удирдлагад**

1. "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл 3288-MON SF" төслөөс 2022 онд “Малчин түмний буян” хоршоонд 153.8 сая төгрөгийн, “Нуурын овоо” хоршоонд 11.8 сая төгрөгийн, “Баян уулын хишиг” хоршоонд 11.8 сая төгрөгийн сүү, мах, арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар нийлүүлсэн байх тул дээрх хөрөнгүүдийг хоршооны үндсэн хөрөнгөнд бүртгэж тайлагнах

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖИЛСАН САНАЛ

**САНАЛ 1.**

Бүгд найрамдах Беларус улсын хөгжлийн банкнаас Трактор Хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл мөн Хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл, Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийг шилэн дансны системд бүртгүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

**САНАЛ 2.**

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаад зээл, тусламж авах, зарцуулах, удирдах, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах саналыг ХХААХҮЯам болон төсөл хэрэгжүүлэгч нэгжид уламжлах